


Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2023 оны 05 дугаар сарын 28 -
ны өдрийн 1157 дугаар тушаалын 3
дугаар хавсралт



УДИРДАМЖ

2023 оны 05 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Дорноговь, Говьсүмбэр аймгийн биеийн тамир,
спортын газрын санхүүгийн үйл
ажиллагаанд дотоод аудит хийх тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 /Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/, 69 дүгээр зүйлийн 69.3 /Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна/ дахь заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Дорноговь, Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны I-IV улирал, 2023 оны эхний 5 сарын хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийж илэрсэн асуудалд чиглэсэн дүгнэлт, зөвлөмж өгөх, цаашид үүсэх эрсдэлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

Хоёр. Дотоод аудитын зорилго

Дотоод аудитын зорилго нь хууль тогтоомж, эрх зүйн актуудын хэрэгжилт, үйл явцын үр нөлөөтэй байдлыг үнэлж дүгнэх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөгөө өгөх замаар байгууллагын үнэ цэнийг нэмэгдүүлэхэд оршино.

Гурав. Дотоод аудитын хамрах хүрээ

2022 оны I-IV улирал, 2023 оны эхний 5 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаа. Үүнд:

- Батлагдсан бүтэц, орон тоо
- Санхүүгийн тайлан тэнцлийн тайлагналт
- Төсвийн санхүүжилт, үндсэн үйл ажиллагааны орлого, зарлага
- Касс, харилцах
- Үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, бусад урамшуулал, нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татварын тайлан
- Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт

- Өмч хөрөнгө, бараа материалын зарцуулалт, ашиглалт, хадгалалт, хамгаалалт
- Худалдан авах ажиллагаа
- Дотоод хяналт
- Аудитын байгууллагын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт

Дөрөв. Дотоод аудитын хамрах хүрээний хязгаарлалт

Дорноговь, Говьсүмбэр аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны I-IV улирал, 2023 оны эхний 5 сар хүртэлх санхүүгийн үйл ажиллагаанаас бусад ажлуудыг дотоод аудитад хамруулаагүй.

Тав. Дотоод аудитын ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Биеийн тамир, спортын улсын хорооны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга Н.Батсүх ахалж, дотоод аудитор Г.Шүрэндолгор, дотоод аудитор Б.Долгион нар ажиллана.

Зургаа. Хэрэгжүүлэх хугацаа

2023 оны 05 дугаар сарын 27-ны өдрөөс 2023 оны 06 дугаар сарын 24-ний өдөр хүртэл

Долоо. Дотоод аудитыг хэрэгжүүлэх гол үе шат

- Байгууллагын үйл ажиллагаа, эрсдэл, дотоод хяналтын тогтолцооны талаар мэдээлэл олж авахын тулд холбогдох баримт бичигтэй танилцах, асуулга авах, албан хаагч нартай уулзалт, ярилцлага зохион байгуулах
- Санхүүгийн тайлан тэнцэл, бусад баримтуудад аудит хийх
- Дотоод аудитын тайлан бэлтгэж, Төсвийн төвлөрүүлэн захирагчид танилцуулах, аудитын үр дүнг эргэн хянах

Найм. Үүрэг хариуцлага

Дотоод аудитад хамрагдаж буй байгууллага:

- Шаардлагатай мэдээлэл, материал, санхүүгийн баримт бичгийг аудитын ажлын багт шаардсан хугацаанд нь саадгүй гаргаж өгөх
- Дотоод аудитыг хэрэгжүүлэхэд холбогдох програм хангамжид нэвтрэх нөхцөл бололцоогоор хангах;
- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж санал, тайлбарыг бичгээр өгөх;
- Дотоод аудитаас гарсан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх.

Дотоод аудитын ажлын хэсэг:

- Дотоод аудитыг явуулахдаа удирдамжийн хүрээнд ажиллах
- Дотоод аудитад хамрагдаж буй байгууллагад хүндрэл учруулахгүй байх
- Дотоод аудитын ажлын явцад хамрагдаж буй байгууллагын мэдээллийн нууцлалыг хадгалах
- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн байгууллагын холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх
- Дотоод аудитаас гарсан дүгнэлт, зөвлөмжийг холбогдох байгууллага, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих

Ес. Дотоод аудитын дүнг тайлагнах

Дотоод аудитын тайланг шалгалтын ажил явагдаж дууссанаас ажлын 5 өдөрт багтаан боловсруулж Төсвийн төвлөрүүлэн захирагчид танилцуулан тайлагнана.

Дотоод аудитын зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж, үр дүнг тооцож ажиллана.

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2023 оны 05 дугаар сарын 26 -
ны өдрийн 4152 дугаар тушаалын 4
дүгээр хавсралт

АУДИТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хэрэгжүүлж эхлэх, дуусах, хугацаа	Хариуцах албан хаагч
1	Байгууллагын үйл ажиллагаатай /дотоод хяналт/ танилцах, мэдээлэл цуглуулах,	3 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
2	Засаглал, эрсдэлийн удирдлага дотоод хяналтын талаар асуулга авах, холбогдох баримт материалтай танилцах	3 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
3	Эрсдэлийн урьдчилсан үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах	2 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
4	Аудитын горим тодорхойлох, хяналт шалгалтыг хийх	5 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
5	Илэрсэн аусуудлын нэгтгэл гаргаж байгууллагын удирдлагад танилцуулах, хариу тайлбар авах	3 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
6	Аудитын тайлан бэлтгэх	3 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
7	Аудитын тайланг удирдлагад танилцуулах	2 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион
8	Аудитын тайланг хүргүүлэх	1 хоног	Г.Шүрэндолгор, Б.Долгион